

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гачингийн Зундуйдамба	Дугаар	L305
Оршин суугаа аймаг	Өвөрхангай	Оршин суугаа сум	Арвайхээр
Төрсөн газар	Арвайхээр	Төрсөн он	1920
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Арвайн хүрээ	Сүм хийдийн дугаар	ӨХАХ 041
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 6	Ярилцлага авсан хүн	Жужа



Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Арвайн хүрээ

Жужа: Энэ хүрээ хэзээ байгуулагдсан бэ?

Гачингийн Зундуйдамба: 1737 онд байгуулсан түүхтэй. Манай энэ хойд талд лам нар ачаа хөсөгтэй энд ирээд Гандпанпунцаглин гэдэг энэ дуганыг 1737 онд байгуулсан.

Жужа: Тэнд хутагт хувилгаан байсан уу ?

Гачингийн Зундуйдамба: Байсан. 5 удаа тодорсон хувилгаан.

Жужа: Тэнд хэдэн лам байсан бэ?

Гачингийн Зундуйдамба: 1000 гаруй ламтай байсан юм.

Жужа. Ямар ямар дуганууд байсан бэ?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гачингийн Зундуйдамба. Цогчин, чойр, жүд, дүйнхор, диваажин, мамба, сандуй, дарь эх.

Жужа. Ламиран дацан?

Гачингийн Зундуйдамба: Мамба , галшаат пог ингээд 11 дацантай байсан.

Жужа: Чойр дацан ямар игчаатай байсан бэ?

Гачингийн Зундуйдамба: Гүнчин игчаатай.

Жужа: Гавжийн дамжаа байсан уу?

Гачингийн Зундуйдамба: Байсан.

Жужа: Та өөрөө аль дацанд нь хурдаг байсан бэ?

Гачингийн Зундуйдамба: Тэнд хоёр чойр байсан юм. Урд чойр, хойд чойр гэж. Урд чойр нь нэг дугантай, хойд чойр нь нэг дугантай.Одоогоор ухаан нь 2 сургууль гэсэн үг л дээ. Чойрын дацанд хурж байсан, би.

Жужа: Чойрын дацангийн гол шүтээн?

Гачингийн Зундуйдамба. Гомбо сахиустай байсан юм. Хүрээнийх бол Лхам, Жамсран хоёр шүтээнтэй байсан юм.

Жужа: Модон дуганууд байсан уу, тоосго уу?

Гачингийн Зундуйдамба. Чойрын , жүдийн хоёр тоосго, сүүлд барьсан дуган. Эхний дуганууд дандаа модон дуган.

Жужа: 2 давхар дуган байсан уу?

Гачингийн Зундуйдамба: Байсан. ганцхан дуган нэг давхар, бусад нь дандаа хоёр давхар.

Жужа: Суварга байсан уу?

Гачингийн Зундуйдамба. Байсан. Хүрээний урд талын зах дээр бурхны найман суварга гэж суварга байсан.

Жужа. Өөр?

Гачингийн Зундуйдамба: Тал талдаа л суваргатай байсан.Гадна талдаа хорооны лам нартай. Хүрээ хороо хоёр нийлдэггүй. Хүрээний урд талд хөдөөгийн энгийн айлууд нь тэрүүгээрээ.

Жужа: Хятадууд байсан уу?

Гачингийн Зундуйдамба: Хятадууд их байсан.

Жужа: Бааюу байсан уу?

Гачингийн Зундуйдамба: Байсан, энчээ ч байдаг байсан.

Жужа: Түвдээс лам нар ирдэг байсан уу?

Гачингийн Зундуйдамба: Ирж байсан.Арвангуравдугаар далай лам манай энд заларч ирж байсан газар даа. Өвөрхангай аймгийн тэр Зүүн Баян улааны тэр Устын голд олон жил байдаг байсан даа.

Жужа: Жас байсан уу?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. 2

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гачингийн Зундуйдамба: Дацан болгон жастай. Цаг цагийн хуралтай, тэр дацангууд чинь.Цаньд чойрын ном үзнэ, энгийн хурал хурчих ая дан, цан тийм юм үзнэ.

Жужа: Аграмбын дамжаа барьдаг байсан уу?

Гачингийн Зундуйдамба: Байсан байсан.

Жужа: Цам бүжиг гардаг байсан уу?

Гачингийн Зундуйдамба: Майдрын цам гэж намрын эхэн сарын шинийн найманд гардаг байсан. 50 гаруй цамтай байсан. Хоёр азар, цагаан өвгөн гээд л олон цамтай. Өвөл бол сортой бас цамтай. Өвлийн адаг сарын 29-нд. Тэрэнд арван хангал, цагаан дарь эх.

Жужа: Ганжуур эргэдэг байсан уу?

Гачингийн Зундуйдамба: Байсан. Жүдийн, чойрын есөн эрдэнийн ганжуур байсан. Цогчин бол зүгээр ганжуур, данжуур эргэдэг байсан.

Жужа: Энд ном барладаг бархан байсан уу?

Гачингийн Зундуйдамба: Бар ихтэй байсан юм. Манай энэ хүрээг барч хүрээ гэдэг байсан. манай энд Баасандорж гэж лам байсан , тэр бол их ном болгоодог. Тэгээд л энэ тэндхийн одоогоор бол зочин гийчний ном энэ тэрийг үзээд л өөрийнхөө аваад байхгүй, ховор ном байвал бичээчдээ өгдөг. Тэгээд л тэр хоёрыг ярьж сууж байхад бичээч нь бичээд л буцаагаад өгчихдөг. Тийм халхад ховор номыг барладаг байсан болохоор барч хүрээ гэдэг байсан юм.

Жужа: Зоч лам нар байсан болов уу?

Гачингийн Зундуйдамба: Байлгүй яахав, тэд нар бол тусгай дацантай. Тэгээд л зод тавьдаг, 30, 40-өөд байсан. 108 булаг, 108 хадан хошуу, 108 ганц мод , 108 үхээр гээд л хамаг болохгүй юмыг л.

Жужа: Хандмаа нар байсан уу?

Гачингийн Зундуйдамба: Миний үед хандмаа байгаагүй. Эмэгтэй хүн энэ хүрээнд хонодоггүй гэдэг байсан юм.

Жужа: Зоч лам хэд байсан бэ?

Гачингийн Зундуйдамба: Тоог нь мэдэхгүй. Олон байсан, би тэр тоог мэдэхгүй. Зочны хоёр талдах тэр дацангийн лам нар мэдэх л байх л даа.

Жужа: Одоо хуучин хүрээний туурь байгаа юу?

Гачингийн Зундуйдамба: Бий. 1990 онд анхны энэ хийдийг дахин сэргээж цугласан юм. Тэгээд ерэн оны хаврын дунд сарын шинийн найманд хуралтай болгосон юм.Хуучин сууж байсан хэдэн лам нар нь үгүй, энэ хуралтай болвол яадаг юм, хаана болдог, хаана болдоггүйг нь үзье гээд. Тэгээд дундаасаа хэд гурван цаас нэмэрлэж байгаад, тэгээд л цуглацгаасан. Бүгд л тэгэхэд мөнгө цаас өгсөн.Энэ дуган байсан газар байна шүү дээ. Тэгээд энэ урьд Арвайхээрийн сүм гэж байсан юм. Тэгээд мань хүн хар болоод хөдөө гараад ядуу зүдүү гээд нэг хонь өгч байсан юм. Тэгээд анх 41 хүн хуралд орсон юм байгаа юм.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. 3

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Хуучин хүрээний шүтээнийг хамгаалж чадсан уу?

Гачингийн Зундуйдамба: За хамгаалсан юм ч ховор байх аа. Зүгээр байх юм нь байдаг юм аа. Чүлтэмпэрэнлэй гэж сайхан зураач байдаг юм. Тэр хүний зурсан бурхад айлуудаар байдаг л юм.

Жужа: Энэ хийдэд хуучны шүтээн байхгүй юу?

Гачингийн Зундуйдамба: Энэ хүрээнд мэдэхгүй, тийм юм дуулдаагүй.

Жужа: Та өөрөө хэдэн онд хар болсон бэ?

Гачингийн Зундуйдамба: Би 1938 онд. Нөгөө лам нарыг барих үед л , залуучуудыг чинь шууд хар болгоод л.Тэгээд л 1938 онд хар болсон доо. Айлуудын хаалган дээр бичиг наагаад л яваад байдаг. Бичиг наачихлээр тэгээд за энэ яваад өгчээ гээд л тийм байсан юм даа , хөөрхий.

Жужа: Одоо яг энэ дуган байсан газар ямар дуган байсан бэ?

Гачингийн Зундуйдамба: Энд Арвайхээрийн тэр таван суварга босгосон юм байгаа юм. Тэрний наад талд тэр жижигхэн дуганд анх хурал эхэлсэн юм. Тэр жүдийн дуган гэж цагаан түүпийн дуган байсан юм. Хоёр цагаан түүпийн дуган, бусдууд нь дандаа мод.

Жужа: Энэ суманд өөр ямар ямар сүм байсан бэ?

Гачингийн Зундуйдамба: Баруун хурал гэж байсан юм.Агь үйзэн вангийн хошуу чинь 5 сумтай байсан юм. Их гол, бага гол , зүүн сум, баруун сум, баруун урд сум гэж. Тэгээд энэ сум болгон тус тусдаа хуралтай. Тэгээд энэ Баруун хурал гэж. Бага гол гэдгийнх нь бол одоо энэ Хүйтний гэж байсан юм. 5 сумтай, 5-уулаа нэг нэг хуралтай байсан юм.

Жужа: Энэ Хар усны хийд байсан уу?

Гачингийн Зундуйдамба. Тэр чинь зүүнийг хэлж байгаа юм.

Жужа: Тэр хэдэн сүмтэй, хэдэн дацантай хийд байсан бэ?

Гачингийн Зундуйдамба: Тэрнийг би сууж байгаагүй сайн мэдэхгүй. Арав гаруй л дугантай байсан байх. Ганжуур эргэдэг тусгай дугантай.

Жужа: Улаан ламын хийд байсан уу?

Гачингийн Зундуйдамба: Тэр байсан юм аа. Тэр баруун сумын хурал. Зүүн сумынх нь тэр Хар ус. Их голынх нь хийд гэдэг нь тэр нэг хүрээ байсан юм.

Жужа: За баярлалаа.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. 4